



“Baabar.niitlech.mn”
ВЭБСАЙТАД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Хуульчдын гудамж 13/1, Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2016.01.11 № 1/81
танай _____-ны № _____-г

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын ерөнхий газрын зүгээс дараахь мэдэгдэлийг хийж байна.

Сүүлийн үед хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг илт мушгин гуйвуулсан, гүтгэлгийн шинж чанартай, сөрөг ташаа мэдээлэл цацах боллоо.

Хамгийн сүүлийн жишээ гэхэд “нийтлэлч Баабар” буюу иргэн Б.Батбаяр 2016 оны нэгдүгээр сарын 11-ний өдөр Baabar.mn вэбсайтад “Бурхан минь, биднийг дээрэмчдээс авраач” гэсэн сүржин хаягтай нийтлэл бичжээ.

Уг нийтлэлдээ ... “Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнууд тэтгэврийн насны ахмадуудтай гэрээр нь очиж уулзан нийгмийн даатгалын байгууллагын амралтанд үнэ төлбөргүй амрахыг уриалдаг, эсвэл тэдний нэрээр нийгмийн даатгалын байгууллагын дарга нарын амралтанд амарсан гэж бичээд нийгмийн даатгалын сангаас мөнгийг хувааж халаасладаг...”, “... мөн сонсголын аппарат өндөр үнэтэй шахдаг...” эдгээр үйлдэлүүдэд нь нийгмийн даатгалын албан хаагчид оролцдог, улс даяар ийм сүлжээ үүссэн гэх мэтээр төрийн байгууллагын нэр хүндэд илт халдсан, эрүүл хүний ой ухаанд багтамгүйгээр гүтгэж бичсэн байна.

Нийгмийн даатгалын байгууллага нь ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, бүрдүүлсэн эх үүсвэрээр хуульд заасан даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгодог байгууллага юм.

Харин Ахмад настнуудыг хөнгөлөлттэй үнээр амралт, сувилалд амрах асуудлыг Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулиар зохицуулдаг бөгөөд аймаг, нийслэлийн Засаг даргын багцаас шууд санхүүжүүлж, аймаг, дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсүүдээр дамжуулан хэрэгжүүлдэг болно.

Мөн дээрхи нийтлэлд дурдсан сонсголын аппарат олгох асуудлыг Нийгмийн даатгалын байгууллага хариуцаж ажилладаггүй бөгөөд “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль”, болон “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль”-ийн дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын багцаас Нийгмийн халамжийн сангаар дамжуулан санхүүжүүлдэг болохыг Танд уламжилж байна.

Иймд Нийгмийн даатгалын байгууллага болон ажиллагсдынх нь нэр хүндэд халдсан, харилцагч түншлэгч байгууллагын итгэлцлэлийг эвдсэн аливаа үндэслэл нотолгоогүй мэдээллийг удаа дараа олон нийтэд тарааж байгаа үйлдэлээ таслан зогсоохыг шаардаж байна.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МЭНДБАЯР